



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
П.БАТБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

0025.0224 № 07/640

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 225,605.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд цалин, урамшуулал, тэтгэмжтэй холбоотой 109,262.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, 7,796.9 мянган төгрөгийн урамшууллыг үндэслэлгүйгээр илүү өгсөн, 2,540.5 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговрыг давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчид 722.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон зэрэг нийт 120,321.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.
- Батлагдсан төсөвт тусгагдаагүй, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн дотоод нөөцийг ашиглаагүйгээр нийт 48,600.0 мянган төгрөгийн зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24-р зүйлийн 24.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 91-р зүйлийн 91.2, 91.2.4, 99-р зүйлийн 99.1, 110-р зүйлийн 110.2, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2-р зүйлийн 2.7, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын 6-р зүйлийн 6.6.2, Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3-р зүйлийн 3.3-т заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь тайлант онд төрийн албан хаагчдын цахим үр чадварыг сайжруулах ажлын хүрээнд 21 аймагт нийт 21805 төрийн албан хаагчийг хамруулан, цахим шилжилтийн бодлого, төрийн үйлчилгээний нэгдсэн системийн ашиглалт, дата хамгаалалт, цахимд зөв байх зэрэг сургалтуудыг зохион байгуулж, нийт 192,041.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Төсөв захирагчийн төсвийн төслийн саналд тусгагдаагүй, тайлант оны төсөвт батлагдаагүй “Цахим шилжилт” арга хэмжээнд дээд шатны төсөв захирагчаас өөрийн төсөвт зохицуулалт хийж 1,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 322,348.8 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Бусад асуудал

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	226,768,281.75	371,435,291.18
33	АВЛАГА	1,171,560.02	27,576,022.05
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	1,171,560.02	394,395.53
33300	Татаас,санхүүжилтийн авлага	-	24,303,982.27
33500	Бусад авлага	-	2,877,644.25
33510	Байгууллагаас авах авлага	-	2,877,644.25
34	УРЬДЧИЛГАА	6,431,856.00	42,912,833.34
34600	Урьдчилж төлсөн зардал	6,401,925.00	42,912,833.34
34710	Урьдчилгаа тооцоо	29,931.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	29,931.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	219,164,865.73	300,946,435.79
35400	Хангамжийн материал	219,164,865.73	300,946,435.79
35410	Бичиг хэргийн материал	12,532,863.23	12,613,042.61
35420	Аж ахуйн материал	33,070,040.00	35,586,445.00
35440	Түлш,шатах тослох материал	-	10,236,627.00
35470	Бусад хангамжийн материал	173,561,962.50	242,510,321.18
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	968,652,732.54	783,133,482.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	968,652,732.54	783,133,482.96
39200	Биет хөрөнгө	958,125,732.54	775,015,482.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(41,333,333.55)
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	825,265,400.00	856,709,324.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	233,344,000.00	235,944,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	12,382,997.09	(57,402,203.23)
39212	Хуримтлагдсан элэгдэл	88,100,670.37	(266,902,304.26)
39300	Биет бус хөрөнгө	10,527,000.00	8,118,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,880,000.00	11,880,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	1,353,000.00	(3,762,000.00)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,195,421,014.29	1,154,568,774.14
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	77,889.91	23,955,642.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,889.91	23,955,642.34
41300	Өглөг	77,889.91	23,955,642.34
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	77,889.91	23,534,331.07
41360	Бусад өглөг	-	421,311.27
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	1,195,343,124.38	1,130,613,131.80
51200	Хуримтлагдсан үр дүн	1,195,343,124.38	1,130,613,131.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,195,343,124.38	1,195,343,124.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	(64,729,992.58)
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,195,421,014.29	1,154,568,774.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,068,826,771.70	7,826,817,988.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,180.00	8,309,520.45
120	Нийтлэг татварын бус орлого	354,180.00	8,309,520.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,666,666.45
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,666,666.45
120009	Бусад орлого	354,180.00	1,642,854.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,068,472,591.70	7,818,508,468.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,936,709,043.70	7,757,622,560.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,936,709,043.70	7,757,622,560.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,763,548.00	60,885,908.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	131,763,548.00	60,885,908.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,873,483,647.32	7,891,547,981.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,873,483,647.32	7,891,547,981.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,288,519,893.54	7,282,715,958.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,801,561,478.74	4,509,666,154.82
210101	Үндсэн цалин	1,783,045,641.46	2,726,388,761.55
210102	Нэмэгдэл	158,964,534.76	701,743,805.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	448,710,000.00	718,001,869.99
210104	Урамшуулал	410,841,302.52	363,531,718.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	346,568,868.42	562,450,300.00
210201	Тэтгэврийн даатгал	237,107,442.36	382,466,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	28,039,845.49	44,996,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,407,513.15	22,498,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,354,591.50	22,498,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	53,659,475.92	89,992,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,759,973.00	539,624,024.12
210301	Гэрэл, цахилгаан	36,380,900.00	32,003,983.11
210303	Цэвэр, бохир ус	40,469,190.00	63,933,500.00
210304	Байрны түрээс	209,909,883.00	443,686,541.01
2104	Хангамж, бараа материалын зардал	150,554,855.68	442,497,577.48
210401	Бичиг хэрэг	27,028,926.29	103,288,481.30
210402	Тээвэр, шатахуун	-	8,317,824.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,285,520.45	249,179,876.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,719,750.00	23,394,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,520,658.94	58,316,544.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,267,948.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,358,948.00	-
210604	Урсгал засвар	23,909,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	176,671,537.00	365,804,824.00
210702	Дотоод албан томилолт	176,671,537.00	365,804,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,348,021.54	602,483,238.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,897,831.32	565,142,744.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	73,904,790.22	32,849,293.53
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,545,400.00	4,491,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	282,787,211.16	260,189,840.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,831,543.70	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,119,000.00	33,960,000.00

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,836,667.46	226,229,840.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	584,963,753.78	608,832,022.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,109,000.00	118,576,237.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,109,000.00	118,576,237.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	459,854,753.78	488,612,931.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	459,854,753.78	488,612,931.18
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэг шилжүүлэг	-	1,642,854.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,195,343,124.38	(64,729,992.58)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,195,343,124.38	(64,729,992.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,068,472,591.70	7,820,572,633.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,064,165.27
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,064,165.27
120009	Бусад орлого	-	2,064,165.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,068,472,591.70	7,818,508,468.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,936,709,043.70	7,757,622,560.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,936,709,043.70	7,757,622,560.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,763,548.00	60,885,908.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,763,548.00	60,885,908.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,068,472,591.70	7,295,851,613.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,068,472,591.70	7,295,851,613.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,483,508,838.42	7,181,806,628.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,802,307,750.48	4,482,680,193.42
210101	Үндсэн цалин	1,785,339,683.40	2,572,893,264.31
210102	Нэмэгдэл	158,964,534.76	828,597,873.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	447,938,189.80	717,722,551.69
210104	Урамшуулал	410,065,342.52	363,466,504.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	346,916,267.29	562,450,300.00
210201	Тэтгэврийн даатгал	237,487,019.25	382,466,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	28,029,010.03	44,996,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,410,007.65	22,498,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,352,424.46	22,498,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	53,637,805.90	89,992,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,759,973.00	512,625,674.12
210301	Гэрэл, цахилгаан	36,380,900.00	37,926,988.72
210303	Цэвэр, бохир ус	40,469,190.00	155,808,489.00
210304	Байрны түрээс	209,909,883.00	318,890,196.40
2104	Хангамж, бараа материалын зардал	162,798,428.45	251,008,808.28
210401	Бичиг хэрэг	33,897,485.00	103,367,095.09
210402	Тээвэр, шатахуун	-	18,554,451.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,285,520.45	75,767,096.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,719,750.00	17,308,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,895,673.00	36,011,765.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,161,528,848.00	12,497,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	940,745,848.00	12,497,700.00

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2107	Томилолт, зочны зардал	176,671,537.00	192,041,063.00
210702	Дотоод албан томилолт	176,671,537.00	192,041,063.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	330,597,390.50	690,069,205.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	223,301,610.50	633,589,205.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	93,750,380.00	46,592,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,545,400.00	9,887,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	215,928,643.70	444,389,761.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,809,643.70	351,323,761.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,119,000.00	93,066,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	584,963,753.28	614,883,333.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,108,999.50	124,206,237.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,108,999.50	124,206,237.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	459,854,753.78	488,612,931.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	459,854,753.78	488,612,931.18
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,064,165.27
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,882,671.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	34,043,924.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	34,043,924.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	34,043,924.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	34,043,924.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	34,043,924.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(34,043,924.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,195,343,124.40	1,195,343,124.40
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	1,195,343,124.40	1,195,343,124.40
Тайлант үеийн үр дүн	-	-	(64,729,992.60)	(64,729,992.60)
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	-	-	1,130,613,131.80	1,130,613,131.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,373,944,100.00	7,269,009,628.82	1,104,934,471.18	86.8
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	8,373,944,100.00	7,269,009,628.82	1,104,934,471.18	86.8
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	8,330,673,200.00	7,181,806,628.82	1,148,866,571.18	86.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,330,673,200.00	7,180,407,463.55	1,150,265,736.45	86.2
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	4,499,602,400.00	4,482,680,193.42	16,922,206.58	99.6
Үндсэн цалин	2,587,128,900.00	2,572,893,264.31	14,235,635.69	99.4
Нэмэгдэл цалин	1,072,577,300.00	828,597,873.33	243,979,426.67	77.3
Унаа хоолны нэмэгдэл	394,303,100.00	717,722,551.69	(323,419,451.69)	182.0
Урамшуулал	445,593,100.00	363,466,504.09	82,126,595.91	81.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	562,450,300.00	562,450,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	382,466,300.00	382,466,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	44,996,000.00	44,996,000.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	35,996,800.00	22,498,000.00	13,498,800.00	62.5
Ажилгүйдлийн даатгал	8,999,200.00	22,498,000.00	(13,498,800.00)	250.0
Эрүүл мэндийн даатгал	89,992,000.00	89,992,000.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	575,285,000.00	512,625,674.12	62,659,325.88	89.1
Гэрэл, цахилгаан	71,379,200.00	37,926,988.72	33,452,211.28	53.1
Цэвэр, бохир ус	160,153,800.00	155,808,489.00	4,345,311.00	97.3
Байрны түрээс	343,752,000.00	318,890,196.40	24,861,803.60	92.8
Хангамж, бараа материалын зардал	278,861,200.00	251,008,808.28	27,852,391.72	90.0
Бичиг хэрэг	103,385,800.00	103,367,095.09	18,704.91	100.0
Тээвэр, шатахуун	20,000,000.00	18,554,451.40	1,445,548.60	92.8
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	102,107,900.00	75,767,096.79	26,340,803.21	74.2
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	17,308,400.00	17,308,400.00	-	100.0
БҮТЭЗүйлс	36,059,100.00	36,011,765.00	47,335.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	334,620,000.00	46,281,524.00	288,338,476.00	13.8
Багаж,техник хэрэгсэл	118,800,000.00	44,741,624.00	74,058,376.00	37.7
Тавилга	215,820,000.00	1,539,900.00	214,280,100.00	0.7
Томилолт, зочны зардал	198,100,000.00	192,041,063.00	6,058,937.00	96.9
Дотоод албан томилолт	198,100,000.00	192,041,063.00	6,058,937.00	96.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	788,532,800.00	690,329,305.00	98,203,495.00	87.6
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	679,504,500.00	633,849,305.00	45,655,195.00	93.3
Мэдээлэл,технологийн үйлчилгээ	98,139,200.00	46,592,900.00	51,546,300.00	47.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	10,889,100.00	9,887,100.00	1,002,000.00	90.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,093,221,500.00	444,389,761.00	648,831,739.00	40.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000,000.00	351,323,761.00	648,676,239.00	35.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,221,500.00	93,066,000.00	155,500.00	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,270,900.00	87,203,000.00	(43,932,100.00)	201.5
Бусад урсгал шилжүүлэг	43,270,900.00	87,203,000.00	(43,932,100.00)	201.5

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,270,900.00	87,203,000.00	(43,932,100.00)	201.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,269,009,628.82	(7,269,009,628.82)	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	7,269,009,628.82	(7,269,009,628.82)	0.0
Улсын төсвөөс санхүүжих	-	7,269,009,628.82	(7,269,009,628.82)	0.0
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-	-	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	174	154	20	88.5
Удирдах ажилтан	31	27	4	87.1
Гүйцэтгэх ажилтан	143	127	16	88.8
Үйлчлэх ажилтан	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	60,885,908.50
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	60,885,908.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	60,885,908.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,003,237.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	37,003,237.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	23,882,671.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,882,671.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	60,885,908.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	60,885,908.50
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	60,885,908.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 683,878.2 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгаагүй		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих орлогыг 63,727.7 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийг 34,492.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.	1	98,219.7			1	98,219.7	1	98,219.7				
Санхүүгийн байдлын тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 48,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 41,333.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг тайлагнасан боловч үндсэн хөрөнгийн тодруулга тайланд шилжүүлсэн авсан үндсэн хөрөнгийг дансны үлдэх өртөг буюу 6,666.7 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.	1	41,333.3			1	41,333.3	1	98,219.7				
Тайлант хугацаанд худалдан авсан 34,043.9 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зардлын биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй байна.	1	34,043.9			1	34,043.9	1	34,043.9				
Мөнгөн гүйлгээний тайлангийн бусад орлогын дүн 1,049.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	1,049.7			1	1,049.7	1	1,049.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд 490,677.1 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна.	1	490,677.1			1	490,677.1	1	490,677.1				
Тайлант онд нийт 18,554.5 мянган төгрөгийн шатахууныг бараа материалд бүртгэлгүй шууд	1	18,554.5			1	18,554.5	1	18,554.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зардлаар бүртгэснээс шатахууны 10,236.6 мянган төгрөгийн талоньг санхүүгийн байдлын тайланд үлдэгдэлгүй, 8,317.9 мянган төгрөгийн зарцуулалтыг үр дүнгийн тайланд тусгаагүй байна.											
Дүн	6	683,878.2			6	683,878.2	6	683,878.2			

3.2 Аудитаар нийт 225,605.9 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрснээс, 11,059.8 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 48,600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 165,946.1 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	
Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж мөнгөн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг баримтлаагүйгээс албан хаагчдын урамшууллыг хавтгайруулан, хувь, хэмжээг нийт 7,061.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	7,061.4	1	7,061.4							
Ажлын зайлшгүй шаардлагын улмаас батлагдсан хуваарийн дагуу ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан нэг хаагчид жилийн эцэст ээлжийн амралтын нөхөн олговрыг 1.5 дахин нэмэгдүүлэн	1	3,276.0	1	3,276.0							

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

олгосон боловч, өмнө тооцогдсон ээлжийн амралтын 2,540.5 мянган төгрөгийг давхардуулан олгосон. Мөн тус албан хаагчид балансын урамшууллыг 735.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.									
Ажлын гүйцэтгэл, мэргэшлийн үр дүн нь "Хангалтгүй" гэж үнэлэгдэн, 3 сарын хугацаанд цалин суутгуулах сахилгын шийтгэл авсан албан хаагчид, тус хугацаанд нийт цалин хөлсийг бүтнээр нь олгож, 722.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	722.4	1	722.4					
Батлагдсан төсөвт тусгагдаагүй, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн дотоод нөөцийг ашиглаагүйгээр нийт 48,600.0 мянган төгрөгийн зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.Үүнд: - Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэх, зөвлөх үйлчилгээ авахад 9,800.00 мянган төгрөг; - Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад 19,000.0 мянган төгрөг; - Байгууллагын бүтэц, албан тушаалд дүн шинжилгээ хийлгэх 19,000.0 мянган төгрөг;	1	48,600.0			1	48,600.0			
Санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: - Төсвийн тохируулгын болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгээгүй; - Урьдчилж олгосон нийт 306 удаагийн дотоод албан томилолтын зардлыг хувь хүмүүс өгөх өглөгөөр бүртгэсэн байна.	1	-					1	-	
Тайлант онд ажил байдлын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа албан хаагч нарт сар бүр илүү цагийн хөлсийг цалин дээр нэмж олгосон. Жилийн эцсийн гүйцэтгэлээр давхардсан тоогоор нийт 335 албан хаагчид 4290 илүү цагийн ажлын хөлс 109,262.03 мянган төгрөгийг үндсэн цалин дээр нэмэлтээр олгосон байна.	1	109,262.0					1	109,262.0	
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж брошур болон талархалын мэндчилгээ хэвлүүлэхэд 36,445.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	36,445.0					1	36,445.0	

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Ажил гүйлгээний утгыг тодорхойгүй бичсэн, тухайлбал "Үйлчилгээний төлбөр" гэсэн гүйлгээний утгатай нийт 49 гүйлгээ гаргасан байна.	1	-					1	-		
Батлагдсан төсөвт тусгагдаагүй, тайлант онд хэрэгжих боломжгүй мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх 18,500.00 мянган төгрөгийн гэрээг 2024 оны 12-р сарын 25-ны өдөр байгуулж, санхүүжилтийг олгож, шууд зардлаар тайлагнасан.	1	18,500.0					1	18,500.0		
Дансны өр төлбөр, тооцоог тухай бүр хянаж, тооцоо нийлж ажиллаагүйгээс цахилгааны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй алдангид 1,739.1 мянган төгрөг төлсөн байна.	1	1,739.1					1	1,739.1		
Дүн	10	225,605.9	3	11,059.8	1	48,600.0	6	165,946.1	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 364,260.1 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 190,471.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 173,788.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 123,429.5 мянган төгрөгийн зардлын 8 гүйлгээ, 29,361.9 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	1	152,791.4	1	152,791.4		
Дүн	1	152,791.4	1	152,791.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төсвийн төслийн саналыг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх онуудын гүйцэтгэлд суурилж, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй, арга хэмжээг ажил үйлчилгээ, тоо үзүүлэлтээр дэлгэрэнгүй ангилан бэлтгээгүй, бөөн дүнгээр төсөвлөсөн байна.	1	-			1	-
Тайлант оны Цахим шилжилт арга хэмжээний батлагдсан төсвийн гүйцэтгэлээр бараа үйлчилгээний бусад зардлаас 173,788.8 мянган төгрөгийн дотоод, гадаад томилолтын зардал гаргасан нь төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зардлын ангиллын бодит гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна.	1	173,788.7			1	173,788.7
Төсөвт тусгагдаагүй интернэтийн үйлчилгээ авах 37,680.0 мянган төгрөгийн шууд гэрээг 4 сарын хугацаатай байгуулж, зардал гаргасан байна.	1	37,680.0	1	37,680.0		
Дүн	3	211,468.7	1	37,680.0	2	-
Нийт дүн	4	364,260.1	2	190,471.4	2	173,788.7